# СОНГОЛОН ХАЙРХАН ХХК-ИЙН ИХ БУЛАНГИЙН ЭЛС ХАЙРГАНЫ ОРДЫН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

(Дархан-Уул аймаг, Дархан, Орхон сум)

Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар: MV-017362



Улаанбаатар хот
2026 он

АГУУЛГА

ОРШИЛ III
БҮЛЭГ 1. ОРДЫН ТАНИЛЦУУЛГА ..... 1-1
1.1 КОМПАНИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ ..... 1-1
1.2 ОРДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ ..... 1-1
1.2.1 Ордын байршил, орчны тойм зураг ..... 1-1
1.3 ҮНДСЭН ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ..... 1-1
1.4 АЖИЛЛАХ ГОРИМ, АЖИЛЛАХ ХҮЧ ..... 1-2
1.5 ХҮЧИН ЧАДАЛ ..... 1-3
1.6 ДЭД БҮТЭЦ ..... 1-4
БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ..... 2-1
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ ..... 3-1
3.1 АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ ..... 3-1
3.2 ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧИНД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ ..... 3-1
3.3 УСАН ОРЧИНД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ ..... 3-1
3.4 БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ ..... 3-1
3.5 ХОГ ХАЯГДЛЫН УЛМААС ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ ..... 3-2
БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 4-1
4.1 ГОЛ ЗОРИЛТ ..... 4-1
4.2 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДЛЫН ХУРААНГУЙ ..... 4-1
4.3 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 4-1
4.4 НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 4-6
4.5 БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 4-6
4.6 НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 4-7
4.7 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 4-7
4.8 ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 4-7
4.9 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 4-8
4.10 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР ..... 4-10
4.11 УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 4-12
4.12 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 4-12
ДҮГНЭЛТ A
ХАВСРАЛТ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ ..... B

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1-1. Уулын ажлын механикжуулалт ..... 1-2
Хүснэгт 1-2. Ажиллах хүч ..... 1-2
Хүснэгт 1-3. Уурхайн ажиллах горим ..... 1-3
Хүснэгт 1-4. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө ..... 1-3
Хүснэгт 1-5. Их Булангийн элс хайрганы ордын геологийн нөөцийн тооцоо ..... 1-3
Хүснэгт 4-1. 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын хураангуй ..... 4-1
Хүснэгт 4-2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө ..... 4-3
Хүснэгт 4-3.Ногоон байгууламжийн төлөвлөгөө ..... 4-6
Хүснэгт 4-4. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө ..... 4-8
Хүснэгт 4-5 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө ..... 4-9
Хүснэгт 4-6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр ..... 4-11
Хүснэгт 4-7. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө ..... 4-12
Хүснэгт 4-8. БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах хуваарь ..... 4-13

Зургийн жагсаалт

Зураг 1-1. Их Булангийн элс хайрганы ордын байршил ..... 1-1
Зураг 4-1. 2026 онд нөхөн сэргээлт хийх газрын байршил ..... Error! Bookmark not defined.

# ОРШИЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрх зүйн баримт бичиг юм.

Сонголон Хайрхан ХХК-ийн  2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Байгаль орчны тухай багц хуулиуд болон тэдгээртэй холбогдон гарсан дүрэм, журам, стандартууд, БОАЖЯ-ны 2021.09.16-ны өдрийн 13/4315 тоот байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлт, 2022 онд Баялаг Эко ХХК-ийн боловсруулсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайлан болон БОАЖС-ын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах,  тайлагнах журмын 3-р хэсэг болох тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгах агуулгад заасны дагуу боловсруулав.

Энэхүү төлөвлөгөөгөөр Дархан-Уул аймгийн Дархан, Орхон сумдын нутагт байрлах MV-017362 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Их Булангийн элс хайрганы ордын үйл ажиллагаатай холбогдон бий болж болзошгүй сөрөг нөлөөллөөс тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны зорилтууд, нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл, хуваарийг тогтоосон бөгөөд 2026 оны БОМТ нь 2022 онд батлагдсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн тав дах жилийн БОМТ юм.

# БҮЛЭГ 1. ОРДЫН ТАНИЛЦУУЛГА


## 1.1 КОМПАНИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

| | |
|---|---|
| **Төслийн нэр** | Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Бетон зуурмагийн үйлдвэр |
| **Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгж байгууллага** | • **Төсөл хэрэгжүүлэгчийн нэр:** Сонголон Хайрхан ХХК<br>• **Улсын бүртгэлийн дугаар:** 9011179051<br>• **Регистрийн дугаар**: 5276764<br>• **Хаяг:** Дархан-Уул аймаг, Дархан сум, 13-р баг<br>• **Утас:** +976 98009669 +976 99220394<br>• **Цахим шуудан:** songolon_h@yahoo.com |

## 1.2 ОРДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

### 1.2.1 Ордын байршил, орчны тойм зураг

Сонголон Хайрхан ХХК-ийн Их Булангийн элс хайрганы ордын талбай нь Дархан-Уул аймгийн Дархан, Орхон сумдын нутагт байрлана. Ордын талбайн хэмжээ 100.53 га бөгөөд байршлыг Зураг 1-1-т тусгав.




*Зураг 1-1. Их Булангийн элс хайрганы ордын байршил*

### 1.2.2 УНДСЭН ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

Их булангийн элс-хайрганы ордын ашиглалтын гүн их биш, үүл-геологийн нөхцөл энгийн тул тээвэртэй ашиглалтын системээр, ил аргаар ашиглана. Усны түвшнөөс дээш элс-хайрга олборлолтыг “экскаватор-автосамосвал”-ын хослолоор явуулна. Усны түвшнөөс доош олборлолтод экскаватор-автосамосвал”-ын хослол дээр нэмэлтээр элс-хайрга сорогч машинаар

(дреджер) олборлолт явуулна. Мөн төсөлд ил уурхайгаас олборлосон элс-хайргыг шигшиж 10 мм ээс доош ширхэглэхтэй хайргыг хэрэглэж байна. Уулын ажлын механикжуулалтыг Хүснэгт 1-1-д тусгав.

*Хүснэгт 1-1. Уулын ажлын механикжуулалт*

| № | Үндсэн тоног төхөөрөмж | Ажиллах объект | Тоо | Хүчин чадал | | Ашиглалтад орсон он |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Нэгж | Хэмжээ | |
| 1. | Экскаватор /Doosan 500 DX 3 м/ | Элс-хайрга олборлолт | 1 | $м^3$ | 3 | 2016 |
| 2. | Дреджер /YLJSD250, 200 $м^3$/ | Элс-хайрга олборлолт | 1 | $м^3$/цаг | 200 | |
| 3. | Ачигч /SEM-650B/ | Тээврийн хэрэгсэлд ачих, шигшүүрийн бункер тэжээх | 1 | $м^3$ | 3 | 2014 |
| 4. | Автосамосвал /Howo, 25тн/ | Элс-хайрга тээвэр | 2 | $м^3$ | 18 | түрээс |
| 5. | Доргиурт шигшүүр /ЗҮК-1245/ | Элс-хайрга шигших | 1 | тн/ц | 15-80 | |
| 6. | Туузан конвейер | Нунтаг материалыг зөөвөрлөх | 1 | тн/ц | 30-60 | |

Экскаватор нь элс-хайрга олборлолтод ажиллахаас гадна уурхайн ашиглалтын эхний жилийн хөрс хуулалтын ажлыг гүйцэтгэж элс-хайрганы нөөцийг нээж олборлолтод бэлдэнэ.

### 1.2.3 АЖИЛЛАХ ГОРИМ, АЖИЛЛАХ ХҮЧ

Уурхай нь улирлын чанартайгаар 5-р сарын 15-наас 10-р сарын 15 хүртэл хоногт 10 цагийн үргэлжлэлтэй 1 ээлжээр ажиллана. Төслийн талбайд нийт 13 хүн ажиллаж байгаа ба уурхайн ажиллах хүчийг Хүснэгт 1-2-д тусгав.

*Хүснэгт 1-2. Ажиллах хүч*

| № | Албан тушаал | Орон тоо | Ажиллах хэсэг |
|---|---|---|---|
| 1 | Уурхайн дарга | 1 | Инженер техникийн ажилчид |
| 2 | Экскаваторын оператор | 1 | Уулын хэсэг |
| 3 | Автосамосвалын жолооч | түрээс | |
| 4 | Утгуурт ачигчийн оператор | 1 | |
| 5 | Дреджерийн оператор | 1 | |
| 6 | Цахилгаанчин | 1 | Үйлдвэрийн хэсэг |
| 7 | Гагнуурчин | 1 | |
| 8 | Нягтлан бодогч | 1 | Захиргаа аж ахуйн хэсэг |
| 9 | Нярав | 1 | |
| 10 | Ах тогооч | 1 | |
| 11 | Тогооч | 1 | |
| 12 | Үйлчилгээний туслах ажилчин | 1 | |
| 13 | Сахиул | 1 | |
| 14 | Нийт | 13 | 4 хэсэг |

Дээрх хүснэгтээс харахад инженер техникийн ажилчид 1 хүн, уулын хэсгийн ажилчид 3 хүн, үйлдвэрийн хэсэгт 2 хүн ажиллах ба захиргаа аж ахуйн хэсэгт 6 хүн ажиллаж нийт 13 хүний ажиллах хүчтэй байна.

Уурхайн ажиллах горимыг тооцоолохдоо бүх нийтийн амралтын өдрүүд болон цаг агаарын гэнэтийн тааламжгүй нөхцөлийн үед ажил саатах хоногийг хасаж тооцоолсон ба тоног төхөөрөмжийн урсгал болон үндсэн засварын хугацааг тоног төхөөрөмжийн төрөл зүйл, хүчин

чадлаас хамааруулан тооцоонд хасаж өгсөн байна. Төсөлд уурхайн жилд ажиллах хоногийг дараах байдлаар тогтоосон байна. Уурхайн ажиллах горимыг Хүснэгт 1-3-д тусгав.

*Хүснэгт 1-3. Уурхайн ажиллах горим*

| № | Үзүүлэлт | Нэгж | Тоо, хэмжээ |
|---|---|---|---|
| 1. | Жилд ажиллах боломжит хоног | хоног | 149 |
| 2. | Цаг агаарын хүндрэл | хоног | 3 |
| 3. | Амралт, баяр ёслол | хоног | 5 |
| 4. | Хоногт, ажиллах ээлжийн тоо | хоног | 1 |
| 5. | Ээлжийн үргэлжлэх хугацаа | цаг | 10 |
| 6. | Ажиллагсдын тоо | хүн | 25 |
| 7. | Уурхайн ажиллах хоног | хоног | 149-3-6=140 |

Дээрх хүснэгтээс харахад улсын чанартай амралт, баяр ёслолын өдрүүд 5 хоног байна. Цаг агаарын хүндрэлийг тооцоолсон өдрүүд 3 хоног байна. Хоногийн нэг ээлжид ажиллах хүний тоо 1 бөгөөд нэг ээлжийн үргэлжлэх хугацаа 10 цаг байх ба уурхайн жилд ажиллах өдрүүд 140 хоног байна.

### 1.2.4 ХҮЧИН ЧАДАЛ

Уг элс хайрганы орд нь жилд 30 мян.м$^3$ элс хайрга олборлох хүчин чадалтай. Уулын ажлын календарьчилсан төлөвлөгөөг Хүснэгт 1-4-д тусгав. Төслийн ТЭЗҮ-д уурхайн ашиглалтын жилийг тооцоолохдоо уулын ажлын 30 жил хүртэл 5 жилээр, 6 үе шатаар төлөөлүүлэн ажлын календарьчилсан төлөвлөгөөг боловсруулсан байна.

*Хүснэгт 1-4. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө*

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | Ашиглалтын жилүүд | | | | | | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 1-5 | 6-10 | 11-15 | 16-20 | 21-25 | 26-30 | |
| 1. | Элс-хайрга | мян.м$^3$ | 162.08 | 150.43 | 172.07 | 149.73 | 162.46 | 147.78 | **944.54** |
| 2. | Хөрс | мян.м$^3$ | 70.57 | 32.81 | 50.99 | 63.13 | 44.83 | 135.81 | **398.14** |
| 3. | Уулын цул | мян.м$^3$ | 232.65 | 183.24 | 223.06 | 212.85 | 207.29 | 283.6 | **1342.68** |
| 4. | Овоолго /Кс= 1.33/ | мян.м$^3$ | 93.86 | 43.63 | 67.81 | 83.96 | 59.62 | 180.63 | **529.52** |

Уулын ажлын календарчилсан төлөвлөгөөнд тусгаснаар уурхайн ашиглалтын 30 жилийн хугацаанд уурхайн үйлдвэрлэлийн нөөц 944.5 мян.м$^3$ элс-хайрга байна. Хөрс хуулалтын хэмжээ 398.14 мян.м$^3$ үүнээс сийрэгжилт тооцсоноор овоолгод 529.52 мян.м$^3$ хөрс байршуулна

***Ашиглалтын нөөц.*** Ордын үйлдвэрлэлийн нөөцийн тооцоог Хүснэгт 1-5-д тусгав.

*Хүснэгт 1-5. Их Булангийн элс хайрганы ордын геологийн нөөцийн тооцоо*

| № | Нөөцийн блок | Элс хайрганы нөөц, м$^3$ | Элс хайрганы нөөц, м$^3$ | |
|---|---|---|---|---|
| | | | Үүнээс: | |
| | | | Элс | Хайрга |
| 1. | B-I | 1,634,273 | 1,358,081 /83.1%/ | 276,192 /16.9%/ |
| | а. Усны төвшнөөс дээш | 372,316 | 309,395 | 62,921 |
| | б. Усны төвшнөөс доош | 1,261,957 | 1,048,686 | 213,271 |
| 2. | B-II | 1,917,235 | 1,560,629 /81.4%/ | 356,606 /18.6%/ |
| | а. Усны төвшнөөс дээш | 256,241 | 208,580 | 47,661 |

| | | | |
|---|---|---|---|
| б. Усны төвшнөөс доош | 1,660,994 | 1,352,049 | 308,945 |
| **Нийт** | **3,551,508** | **2,918,710** | **632,798** |
| а. Усны төвшнөөс дээш | 628,557 | 517,975 | 110,582 |
| б. Усны төвшнөөс доош | 2,922,951 | 2,400,735 | 522,216 |

Уурхайн үйлдвэрлэлийн нөөцийн тооцоог ордын нийт нөөцийн хэмжээнд авч үзвэл нийт 3325.44 мян.м$^3$ элс-хайрганы нөөцтэй байна.

## 1.3 ДЭД БҮТЭЦ

**Усан хангамж:** Ажилчид уурхайн талбайд байрлахгүй бөгөөд зөвхөн ажлын цагаар олборлолт явуулна. Ажилчид Сонголон Хайрхан ХХК-ийн бетон зуурмагийн үйлдвэрийн харьяанд байрлах ажилчдын байранд байрлана.

Уурхайн ахуйн ус хангамжийг Дархан-Ус суваг ХК-тай байгуулсан цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах гэрээгээр зохицуулдаг.

**Цахилгаан хангамж:** Уурхайн олборлолт явуулах нийт талбай их биш тул олборлолт явуулах техник хэрэгсэл нэг дор төвлөрсөн мөн талбайн хажуугаар өнгөрөх Дархан-Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээний 10кВ-ийн өндөр хүчдэлийн шугамаас ТМ3-1600/35/0.4 төрлийн бууруулах трансформатор ашиглан цахилгаан эрчим хүчээр хангагдаж байна.

# БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

**Физик газарзүй:** Төслийн талбай нь Хангай- Хэнтийн уулархаг их мужийн баруун хойд салбар уулсын хүрээнд Шарын голын районд харьяалагдана. Гадаргуугийн хамгийн нам цэг нь Шарын голын хөндийд 790 м, хамгийн өндөр цэг нь талбайн урд хэсэгт орших Их Дархан уул 1242.3 м хүрэх бөгөөд харьцангуй өндөржилт нь 50-600 м-ийн хооронд хэлбэлзэнэ. Нийт нутаг нь өвс ургамлаар бүрхэгдсэн, чулуулгийн гарш илэрц муу, харин уулын өмнөд хажуунууд чулуулгийн гарш илэрц сайтай, заримдаа бага хэмжээний нуранги, хад цохиотой байдаг.

**Уур амьсгал:** Төслийн талбай байрлах Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэр нь Монгол орны уур амьсгалын мужлалын ерөнхий ангиллаар хуурайдуу сэрүүн зунтай, хахир өвөлтэй мужид хамаарагдана. Уг бүс нутагт VII сарын дундаж агаарын температур нь +17- (+20)°С, хоногийн дундаж агаарын температур +10°С-ын заагийг хавар V сарын сүүлч, намар IX сарын дунд үед тус тус дайрч, энэ үеийн үргэлжлэх хугацаа нь 111-120 хоног, уулархаг хэсэгтээ 105-110 хоног байдаг. Энэ хугацаанд 1750-2250°С-ын нийлбэр дулаан хуримтлагддаг. Хаврын цочир хүйтрэл олон жилийн дунджаар V сарын 25-аас VI сарын эхээр шувтарч, намрын анхны цочир хүйтрэл VIII сарын сүүлч, IX сарын эхээр тохиолддог.

**Усан орчин:** Төслийн талбай нь олон жилийн цэвдгийн тархалтын бүслүүрийн хувьд олон жилийн цэвдэг чулуулаг үргэлжилсэн тархалттай бүслүүрт хамаарч байна. Мөн төслийн талбай нь Хараа голын сав газарт хамаарагдах бөгөөд ойр орчимд ил усны тогтолцоо болох ундны ус, гол горхи, булаг шанд байхгүй байна. Төсөл хэрэгжих талбайд голын сүлжээ сайн хөгжсөн ба Ерөө голын /Орхон голын баруун цутгал/ болон Хараа голын сав газарт хамаарна.

**Хөрсөн бүрхэвч:** Их булангийн элс хайрганы орд орчмын бүс нутаг нь хээр бүхий экосистемтэй, д.т.д 673-676 м үнэмлэхүй өндөртэй голын хөндий, хуучин татам бүхий газрыг дамнан байрлах бөгөөд хөрсөн бүрхэвч нь хүрэн хөрсний дэд хэв шинжид багтах Глейрхэг элсэнцэр Хүрэн, Хужирлаг элсэнцэр Хүрэн, Мараалаг элсэнцэр Хүрэн төрлийн хөрснүүд тархсан байна. Эдгээрээс глейрхэг элсэнцэр хүрэн ба мараалаг шавранцар хүрэн хөрс талбайн 85% орчимд зонхилон тархсан байна. Эдгээр хөрс нь ерөнхий үржил шимийн түвшин бага буюу ялзмагийн агууламж нь 1-2%, дундаж зузаан үе давхаргатай, хөрс үүсгэгч хурдас нь чулуу багатай нарийн элсэрхэг ба тоосорхог хагшаастай, шороон зам зэрэг техникийн нөлөөтэй эвдрэл талхагдалд дунд зэрэг тэсвэртэй, эргэж нөхөн сэргэхдээ мөн дунд зэрэг байна.

**Ургамлан нөмрөг:** Дархан-Уул аймгийн Дархан, Орхон сумын нутаг дэвсгэр нь Монгол орны ургамал-газарзүйн тойргоор Монгол Дагуурын ойт хээрийн тойрогт багтдаг. Төслийн талбай нь голын хөндий, нам дор газар бөгөөд дэрс-улалжит бүлгэмдэл зонхилж ургасан. Талбайд 9 овгийн 13 төрлийн 14 зүйл дээд ургамал бүртгэгдсэн.

**Амьтны аймаг:** Төслийн талбайн орчимд тохиолдох боломжит зүйлүүдээс ховордож болзошгүй хоёр амьтан /үнэг, хярс/ байна. Шувуудаас төслийн талбайд элбэг тохиолдох 5 багт хамаарах 16 зүйл байна. Эдгээр шувууд нь оршин амьдрах хэлбэрээр өндөглөн зусдаг болон суурин шувууд байна. Төслийн талбай орчимд хоёр нутагтан, мөлхөгчдийн цөөн хэдэн зүйл тархсан байна. Үүнд гүрвэлээс цоохор хонин гүрвэл *Phrenocephalus versicolor,* монгол гүрвэл *Eremias agrus,* могойноос бамбай хоншоорт *Gloydius halys,* Рашааны могой *Elaphe dione* зэрэг тохиолдох боломжтой юм. Ховор болон нэн ховор зүйлүүд хайгуул судалгаагаар тэмдэглэгдээгүй байна.

**Дархан-Уул аймаг:** Дархан-Уул аймаг нь Монгол орны хойд хэсэгт Хэнтийн нурууны салбар уулсын дунд Хараа голын зүүн хойд хөндийг хамарсан 327.5 мянган га газар нутагтай. Нийт газар нутгийн 70.7 хувь буюу 231.7 мянган га газрыг ХАА-н эдэлбэр газар эдэлдэг. Засаг захиргааны нэгжийн хувьд Дархан, Орхон, Хонгор, Шарын гол гэсэн 4 сум, 26 багтай.

**Дархан сум:** Монгол орны аж үйлдвэрийн томоохон төв Дархан хотын анхны суурийг тухайн үеийн Давхрын төмөр замын өртөө, барилгын түүхий эдийн ордуудыг түшиглэн 1961 оны X сарын 17-ны өдөр тавьсан юм. УИХ-н 1994 оны 32-р тогтоолоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу Дархан хотыг Дархан-Уул аймаг болгон өөрчилсөн. Түс хот нь хуучнаар эдийн засгийн харилцан туслалцах зөвлөлийн гишүүн орнууд болох Зөвлөлт Холбоот Улс, Болгар, Польш, Унгар, Чехословак, Герман зэрэг улсуудын техник, эдийн засгийн хамтын ажиллагааны тусламжтайгаар байгуулагдсан. Мөн Дархан хотыг Найрамдлын хот хэмээн нэрлэсээр ирсэн.Дархан-Уул аймаг нь Монгол орны хойд хэсэгт Хэнтийн нурууны салбар уулсын дунд Хараа голын зүүн хойд хөндийг хамарсан 327.5 мянган га газар нутагтай. Нийт газар нутгийн 70.7% буюу 231.7 мянган га газрыг ХАА-н эдэлбэр газар эдэлдэг. Түс аймгийн газар нутгийн хэмжээ бага боловч алт, шохойн чулуу, нүүрс, барилгын материалын төрөл бүрийн түүхий эд зэрэг байгалийн баялгийн нөөц ихтэй.

**Орхон сум:** Дархан-Уул аймгийн Орхон сум нь анх 1968 онд Орхон Шарын голын бэлчирт одоогийн Сэлэнгэ аймгийн Орхон Шарын голын Жимс, Ногоо, Сүүний САА нэртэйгээр үүсгэн байгуулагдсан бөгөөд 1974 онд БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор Дархан хотод шилжиж Орхон хороо, улмаар 1994 онд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өөрчлөлтөөр Баян-Өлзийт, Энхтал гэсэн хоёр багтайгаар Орхон сум болж өөрчлөн байгуулагдсан. Орхон сум нь 44177 га талбай бүхий нутаг дэвсгэртэй, нийслэл Улаанбаатар хотоос 275 км, аймгийн төвөөс 45 км зайд байрладаг ба түс сум нь 2 багийн зохион байгуулалттай.

# БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

## 3.1 АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

Их Булангийн элс хайрга олборлох төслийн нийт хугацаанд агаарын чанарт үзүүлэх гол нөлөөлөл нь хөрс хуулах, овоолго үүсгэх, хүдэр бутлах, машин механизмын хөдөлгөөнөөс тоос босох, дуу чимээ үүсэх, хорт хий ялгарах зэрэг үйл ажиллагаанууд хамаарч байна. Түхайлбал:

- Хөрс хуулж элс хайрга олборлох үед 5 жилийн хугацаанд 93.86 мян.м$^3$ хөрс хуулах бөгөөд овоолгоос ашиглалтын улмаас тоос, тоосонцор үүсэх
- Уурхайн тээврийн замаас тоос, тоосонцор ялгарах
- Технологийн шат дамжлага бүхий ангилан ялгах, бутлах процессоос тоос үүсэх
- Элс хайрга олборлож, ангилан буталж, ачиж тээвэрлэх зэрэг процессоос тоос үүсэх

## 3.2 ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧИНД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

- Олборлолтын улмаас нийт 70.4 мян.м$^3$ хөрс зайлуулагдах
- Ил уурхайн карьерын талбай буюу 14 га талбайн газрын гадарга үндсэн хэв шинжээ алдах
- Хөрсний овоолгыг 4.5 га талбайд үүсгэх бөгөөд тухайн талбайн газрын гадарга үндсэн хэв шинжээ алдах
- Ил уурхайгаас хуулах хөрсийг автосамосвалаар 0.4-0.9 км замаар даацын машин механизмын нөлөөгөөр хөрсөн бүрхэвч элэгдэж, эвдрэл өртөх
- Ахуйн хатуу болон шингэн хог хаягдал, шатах тослох материал болон нефтийн бүтээгдэхүүний асгаралтаас хөрсөн бүрхэвч бохирдох

## 3.3 УСАН ОРЧИНД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

- Зам талбайн усалгаа, биологийн нөхөн сэргээлтэд шүүрлийн усыг зохисгүй ашигласнаар усны нөөцөд хомсдох
- Түсгай элс сорогч механизм ашигласнаар ус элс хайрганы холимог бий болох ба энэ холимгийг бэлдсэн далан дээр асгаж, шүүрлийн усыг тогтсон цөөрөмд нийлүүлснээр нуур цөөрөм үүсэх
- Ахуйн хатуу, шингэн хог хаягдлыг зүй зохистой зайлуулахгүй тохиолдолд гадаргын усыг бохирдуулах

## 3.4 БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

- Уурхайн олборлолт, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, хайрга бутлах үйл ажиллагаа болон байнгын газар шорооны ажилтай холбоотойгоор үүсэх тоосжилт ургамлан нөмрөгт дам нөлөөлөл үзүүлэх
- Олборлолтоос тоос үүсэж ойр орчмын талбайн ургамлан нөмрөг тоосонд дарагдах
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний нөлөөгөөр ургамлын нөмрөг талхлагдах, доройтох
- Шимт хөрс, хүдрийн овоолго байгуулах талбайн ургамлын нөмрөг дарагдаж, үндсэн хэв шинж чанараа алдах
- Хөрсөнд үүрлэн амьдрагч жижиг хөхтөн амьтад, бусад шавж зэрэг амьд биетүүдийн амьдрах орчин алдагдах, уурхайн үйл ажиллагаанд өртөх, устах
- Элс хайрга олборлолтын улмаас үүссэн ухмал нүх, нуурт амьтан орж, унаж бэртэх

## 3.5 ХОГ ХАЯГДЛЫН УЛМААС ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

- Ахуйн хог хаягдал: Уурхай болон оффист нийт 12 хүн ажиллах бөгөөд нэг хүн хоногт 0.5 кг хог хаягдал гаргана гэж тооцоолоход өдөрт 12.5 кг, жилд 1.75 тонн хатуу хог хаягдал үүсэх
- Шингэн хог хаягдал: Хоногт 3,750 л ус хэрэглэх бөгөөд үүний 70 хувийг ахуйн шингэн хаягдал болно гэж тооцвол хоногт дунджаар 2,625 л буюу 2.6 $м^3$ шингэн хаягдал гарах
- Аюултай хог хаягдал: Элс хайрганы олборлолтоос гарах хаягдал, хаягдал тос ба шингэн түлшний хаягдал, хаягдал дугуй, батарей, машин механизмыг задлах болон засварлах үйл ажиллагаанаас гарах хаягдлууд үүсэж болзошгүй.

# БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

## 4.1 ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

БОМТ нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт Их Булангийн элс хайрганы ордын үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгахаар хуульчлагдсаныг баримтлан БОХТ, ОХШХ-ийг боловсруулав.

## 4.2 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДЛЫН ХУРААНГУЙ

Сонголон Хайрхан ХХК-ийн Их Булангийн элс хайрганы ордын 2026 оны БОМТ-г Байгаль орчин аялал жуулчлалын яамны сайдын 2019 оны 10-дүгээр сарын 29-ны өдрийн А/618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 3-р хэсэг болох тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгах агуулгад заасны дагуу хийж гүйцэтгэсэн ба төслийн БОННҮ тайланд тусгасны дагуу 2026 оны БОМТ-г авч хэрэгжүүлэхэд **₮45,840,000** зарцуулахаар төлөвлөж, барьцаа 50%-ийн төлбөрийг холбогдох дансанд байршуулсан.

*Хүснэгт 4-1. 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын хураангуй*

| № | | Байгаль орчны менежментийн төлөвлөгөө | Нийт зардал, ₮ |
|---|---|---|---|
| 1. | Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө | 2,800,000 |
| 2. | | Ногоон байгууламжийн төлөвлөгөө | 13,030,000 |
| 3. | | Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө | 21,000,000 |
| 4. | | Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | 2,650,000 |
| 5. | | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө | 360,000 |
| 6. | | Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө | 1,000,000 |
| 7. | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | 5,000,000 |
| | | ***Нийт зардал*** | **45,840,000.00** |

## 4.3 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Сонголон Хайрхан ХХК-ийн 2022 онд батлагдсан БОННҮ-ний нэмэлт тодотгол тайлангийн 5 жилийн БОМТ-ний сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнд нийт 30 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Сонголон Хайрхан ХХК нь сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд өмнөх онуудад дараах ажлуудыг хийж гүйцэтгэн, тогтмол хэрэгжүүлж байна. Үүнд:

- Уурхайн дотоод тээвэрлэлт нь 0.5-1.0 км зайд хийгдэх бөгөөд тээвэрлэлтийн замд 5 болон 20 км/цаг хурдтай явах 2 ш тэмдэг тэмдэглэгээг байрлуулсан

- Уурхайн нь жилд 140 хоног ажиллах бөгөөд ажиллаж байх хугацаандаа 2 сар тутамд уурхайн дотоод замын сүлжээг сайжруулан ажилласан.
- Уурхайн тээвэрлэлтийн 1.2 км  замын тоосжилт дарах усалгааг 5-9 сард хийж орчны тоос шороог дарж, орчны агаарт үзүүлэх нөлөөллийг бууруулж ажилласан.
- Уурхайд экскаватор болон ковшийг хэрэглэх бөгөөд тэдгээрийн үзлэг оношилгоог аймгийн техникийн хяналтын үзлэг оношилгоонд жил бүр хамруулж, хэвийн ажиллагааг хангаж ажилласан.
- Санамсар болгоомжгүй байдал, осол эрсдлийн улмаас шатах тослох материал алдагдсан тохиолдолд саармагжуулах  хэрэгслийг уурхайд байрлуулсан бөгөөд Сонголон Хайрхан ХХК нь 2022.04.10-ний өдрийн № 12 тоот компанийн дотоод тушаалаар “Үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх орон тооны бус комисс”-ыг байгуулж,  асгаралтаас сэргийлэх дотоод журмыг боловсруулан, түүнийг дагаж мөрдөн ажиллаж байна.
- Ариун цэврийн байгууламжийг эко, био аргаар болон орчин үеийн шийдлээр хөрсөнд нөлөөлөлгүй байдлаар шийдэж, био нойлыг төслийн талбайд суурилуулсан.
- Дархан хотын тохижилт үйлчилгээний газар ОНӨААТҮГ-тай 2022.09.01-ний өдөр 26 тоот хамтран ажиллах гэрээ байгуулсан.
- Уурхайн ажилчид уурхайн талбайд байрлахгүй бөгөөд ажилчдын ажлын цагийн хэрэглээний ахуйн усыг Дархан-Ус суваг ХК-тай цэвэр ус хангах, бохир усыг татуулах 2017.04.24-ний өдрийн 767 тоот гэрээний дагуу үйлдвэрээс авч ажиллаж байна.
- Сонголон Хайрхан ХХК нь 2022 оны БОМТ-ний хүрээнд лицензийн талбайн зүүн хойд талд 220 ш, 2023 онд 100 ш агч, улиас, бургас, 2024 онд нэмж тарьсан 120 ширхэг мод, 2025 оны нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хүрээнд уурхайн талбайд тариалсан нийт 430 ш модны арчилгаа тордолгоог тухай бүрд нь хийв.

Их Булангийн элс хайрганы ордын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөлд өртөх орчноор буюу агаарын чанар, хөрсөн бүрхэвч, усан орчин болон ургамлан нөмрөг зэрэг байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр БОННҮ-д тусгасны дагуу 2026 оны БОМТ-ний сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан Хүснэгт 4-2-д тусгав.

*Хүснэгт 4-2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө*

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Хамрах хүрээ | Тоо хэмжээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал, ₮ | Нийт зардал, ₮ | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| *Агаарын чанар* | | | | | | | | | |
| 1. | Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр тоосжилт үүсэх | Уурхайн тээвэрлэлтийн замын тоосжилтыг бууруулахын тулд усалгаа хийх | Уурхайн тээвэрлэлтийн зам | 1.2 | км | 600,000 | | 5-9 сард 2 удаа | -2022-2026 оны БОМТ-ний 9.3.1-т тусгаснаар |
| 2. | Тээврийн хэрэгслүүдийн түлшний шаталт агаар орчныг бохирдуулж болзошгүй | Уурхайд хэрэглэгдэж буй тээврийн хэрэгслээс ялгарах хорт утааг стандартын түвшинд байлгах, хуваарьт үзлэг, оношилгоонд тогтмол хамруулах | Экскаватор, ковш | 2 | ш | 30,000 | 60,000 | Жилд 1 удаа | |
| *Хөрсөн бүрхэвч (газрын гадарга)* | | | | | | | | | |
| 3. | Хөрсний элэгдэл үүсэх | Тээвэрлэлтийн зам дагуу хурдны хязгаарлалтыг заасан тэмдэг тэмдэглэгээний элэгдэж гандсан хаяг шошгыг арчилж, тоос шороог цэвэрлэх | Тэмдэг тэмдэглэгээ | 2 | ш | Уурхайн ажилчид гүйцэтгэх | | Улиралд 1 удаа | - MNS:5011:2020. Авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг хийх заавар. Ерөнхий шаардлага |
| 4. | Хөрс бохирдох | Болзошгүй байдлаар шатах тослох материал асгарсан тохиолдолд хэрэглэх саармагжуулах иж бүрдлийн хэрэгслийг нэмж байрлуулах | Уурхай, галын булан | 2 | ш | 150,000 | 300,000 | Жилд 1 удаа | |
| 5. | Хог хаягдлаар хөрс бохирдох | Хог хаягдлыг цэвэрлэх, бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулах | уурхайн талбай | 12 | удаа | 50,000 | 600,000 | Сард 1 удаа | |
| 6. | | | орчны 50 м | 4 | удаа | 50,000 | 200,000 | Улиралд 1 удаа | |

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Хамрах хүрээ | Тоо хэмжээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал, ₮ | Нийт зардал, ₮ | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 7. | | Хог хаягдлыг журмын дагуу хадгалж гэрээний дагуу тогтоосон хугацаанд тээвэрлэх | Уурхайн кемп | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгав. | | | | | |
| 8. | Хөрс талхлагдах | Тээврийн хэрэгслийн зогсоолд хурдны хязгаарлалт болон зогсоолын тэмдэг тэмдэглэгээний бүрэн бүтэн байдлыг хянах | авто машины зогсоол | 4 | удаа | - | | Улиралд 1 удаа | -Эрүүл ахуйн тухай хууль |
| 9. | Байгалийн гаралтай цацраг идэвхт элемент (Ra-226, Th-232, K-40) бетон зуурмагт агуулагдах, барилга ашиглалтын үед хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл | Итгэмжлэгдсэн лабораториор бетон зуурмаг болон түүхий эдээс дээж авч гамма-спектрометрийн шинжилгээ хийх; стандартын хязгаараас хэтэрсэн тохиолдолд тухайн түүхий эдийг ашиглахгүй байх | Барилгын зориулалтаар ашиглах бүх бетон зуурмаг | 2 | Ш | 45,000 | 90,000 | Жилд 1 удаа | Холбогдох шаардлага, стандартын дагуу |
| *Усан орчин* | | | | | | | | | |
| 10. | Ногоон байгууламжийн ургалт доройтох | Лицензийн талбайд тарьсан модыг усалж, арчилгаа тордолгоог хийх | Мод тарьсан талбай | | ш | 950,000 | | 4.20-5.1 (1), 5.1-6.1 (4), 6.15-8.15 (9), 8.15-9.15 (2) | Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4 |
| 11. | Ус ашиглалт нь Хараа–Ерөө ай | Хараа–Ерөө голын сав газрын захиргаагаар ус ашиглалтын | Төслийн ус ашиглалт, | 1 | удаа | - | | Жилд 1 удаа | Усны тухай хууль, Байгаль |

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Хамрах хүрээ | Тоо хэмжээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал, ₮ | Нийт зардал, ₮ | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| | савын гадаргын болон газрын доорх усны нөөц, чанарт сөрөг нөлөө үзүүлэх, усны горим алдагдах эрсдэл | дүгнэлт гаргуулах; ус ашиглалтын хэмжээ, горимыг дүгнэлтийн дагуу мөрдөх; шаардлагатай тохиолдолд ус хэмнэх арга хэмжээ хэрэгжүүлэх | ус татах бүх эх үүсвэр | | | | | | орчныг хамгаалах тухай хууль, Хараа-Ерөө голын сав газрын захиргаанаас гаргасан журмууд |
| Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний нийт зардал | | | | 2,800,000 ₮ | | | | | |

## 4.4 НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Сонголон Хайрхан ХХК нь 2022 онд хүрээнд лицензийн талбайн зүүн хойд талд 220 ш, 2023 онд 100 ш агч, улиас, бургас, 2024 онд нэмж тарьсан 120 ширхэг мод, 2025 оны нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хүрээнд уурхайн талбайд тариалсан нийт 430 ш модны арчилгаа тордолгоог тухай бүрд нь хийж гүйцэтгэн ажиллаж байна.

2026 оны ногоон байгууламж, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хүрээнд:

### Ногоон байгууламж

- Уурхайн талбайд 100 ширхэг мод нэмж тарина. Мод тарих байршил, төрөл зүйлийг орон нутгийн уур амьсгал, хөрсний онцлогт нийцүүлэн сонгоно. Арчилгаа, усалгааг улирлын хугацаанд тогтмол хийнэ.

### Нөхөн сэргээлтийн ажлууд

- Уурхайн талбайн хашааны ажлыг бүрэн дуусгаж, хамгаалалтын шаардлага хангасан байдлаар ашиглалтад оруулна. Мөн 79 тохойн хашаа/хил заагийн ажлыг бүрэн гүйцэтгэж, холбогдох байгууллагад хүлээлгэн өгнө. Хүлээлгэн өгсөн тухай акт, баримт бичгийг бүрдүүлнэ. Эргийн дагуух техникийн нөхөн сэргээлтийг гүйцэтгэж элэгдэл, нурж эвдрэх эрсдэлтэй хэсгийг засаж, тэгшлэх, бэхжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

*Хүснэгт 4-3.Ногоон байгууламжийн төлөвлөгөө*

| Зорилт | Арга хэмжээ | Арга хэмжээний цар хэмжээ | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн зардал, төг | Нийт зардал төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| *1* | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| Мод тарьж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх | Суулгац авах | Уурхайн лицензийн талбай | ш | 100 | 5,000 | 500,000 | 2026 оны хавар эсвэл намрын улиралд тариалах | -Мод тарих гарын авлага |
| | Экскаватор, авто ачигч ажиллуулах | | ш | 2 | | 800,000 | | |
| | Мод услах (усны машин) | | ш | 1 | | 250,000 | | |
| | Ажилчдын цалин | | хүн | 5 | 100,000 | 500,000 | | |
| | Хашаалалт, хамгаалалтын тор | | ш | 100 | 40,000 | 4,000,000 | | |
| | Арчилгаа, нөхөн тарилт | | | - | | 6,980,000 | | |
| **Нийт зардал** | | | | **13,030,000 ₮** | | | | |

Ногоон байгууламжийн төлөвлөгөөнд 13,030,000 ₮ төгрөг зарцуулахаар байна.

## 4.5 ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Сонголон Хайрхан ХХК нь 2026 онд Дархан, Орхон сумын бэлчээрийг сайжруулах, эвдэрч орхигдсон газрыг нөхөн сэргээх ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Энэ хүрээнд орон нутгийн удирдлага, байгаль орчны мэргэжилтнүүдтэй хамтран сумын отрын бүсийн бэлчээрийг хашиж, хамгаалах, худаг, булгийн эхийг хаших, эвдэрсэн худгийг сэргээн засварлах, доройтсон ойг нөхөн сэргээх, тарьц суулгацаар хангах арга хэмжээг зохион байгуулах юм.

Мөн техникийн нөхөн сэргэлтийн хүрээнд ухагдаж үлдсэн ухашийг дүүргэх, овоолгыг хэлбэржүүлэх, хөрс тараан тэгшлэх, биологийн нөхөн сэргэлтийн хүрээнд олон наст ургамал тарих ажлыг гүйцэтгэнэ. Үүний хяналт, мониторингын хүрээнд усалгаа, арчилгаа, тордлогын арга хэмжээг тогтмол явуулж, нөхөн сэргээгдсэн талбайн үр дүнг хянах юм.

Эдгээр үйл ажиллагаанд нийт 21 сая төгрөгийг төсөвлөсөн бөгөөд 2026 онд дээрх арга хэмжээг Дархан, Орхон сумын эвдэрч нөхөн сэргээх шаардлагатай талбайд хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

## 4.6 НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Их Булангийн элс хайрганы ордын талбай орчимд эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд орших иргэд, айл өрхүүд байхгүй учир нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг төлөвлөөгүй болно.

## 4.7 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Сонголон Хайрхан ХХК нь Улаанбаатар их сургуулийн Түүх, археологийн тэнхимээр 2021 онд Археологийн авран хамгаалах хайгуул судалгааны ажлын тайланг боловсруулсан бөгөөд тус тайланд “Талбайд хайгуулын ажлыг хийж гүйцэтгэхэд ямар нэгэн археологи, түүхийн дурсгал илэрч олдоогүй. Хайгуул судалгааны ажлыг гүйцэтгэх үед талбайн ихэнх хэсэгт газар шорооны ажил гүйцэтгэж, хөрс хуулснаас гадна хиймэл усан сан үүсгэсэн байна. Усан сангийн талбайн доор болон газар шорооны ажлын явцад түүх соёлын ямар нэг дурсгал сүйдсэн, устсан байхыг үгүйсгэх аргагүй юм. Тиймээс цаашид Сонголон хайрхан ХХК нь хөрс шорооны ажлын явцад түүх соёлын дурсгал илрэн олдвол нэн даруй, зохих хууль ёсны дагуу мэргэжлийн байгууллагад хандан хамтран ажиллах”-ыг зөвлөсөн байна.
Мөн ШУА-ийн Палеонтологийн хүрээлэнгээр Палеонтологи судалгааны ажил хийлгүүлсэн бөгөөд 2021.10.11-ний өдрийн № Т/83 тоот дүгнэлтэй. Түс дүгнэлтэд “Судалгааны талбайн хэмжээнд дөрөвдөгч, орчин үеийн насны элс, шавар, шавранцар, хайрга, конглометар, гравелит, тунамал терриген хурдас чулуулаг тархсан ба хурдас чулуулгаас эртний шим ертөнцийн олдвор илрээгүй тул цаашид түсгай зөвшөөрлийн ажил явуулахад татгалзах зүйлгүй” гэж дүгнэсэн байна.
Иймд Сонголон Хайрхан ХХК нь 2026 онд түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлагагүй.

## 4.8 ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Сонголон Хайрхан ХХК-ийн 2022 онд батлагдсан БОННҮ-ний тайлангийн 5 жилийн БОМТ-ний осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд нийт 3 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Сонголон Хайрхан ХХК нь осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хүрээнд 2025 он хүртэлх хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэн, тогтмол хэрэгжүүлж байна. Үүнд:

- Гал унтраах багаж, хэрэгслийг кемпийн баруун урд талд байрлуулсан.
- Уурхайд ажилчдыг ХАБЭА сургалтыг хамруулдаг.
- 2022 оны төлөвлөгөөнд тусгасны дагуу ажилчдыг Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлгийн Поликлиник-тэй хамтран эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан.
- Уурхайн кемпэд анхны тусламжийн эмийн санг байрлуулсан.

Сонголон Хайрхан ХХК нь эрсдэлийн үнэлгээгээр тогтоогдсон аюул ослоос урьдчилан сэргийлж, эрсдэлийг бууруулах, арилгах талаарх хууль, дүрэм, журмын дагуу ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны журмыг нэвтрүүлэн ажиллахаар 2026 оны осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд 2,650,000 ₮ зарцуулахаар төлөвлөв.

*Хүснэгт 4-4. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө*

| 1 | 2 | 3 | 4 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Уурхайд ажиллаж буй ажилчид бэртэж, гэмтэх | Хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар давтан зааварчилгааг мөрдүүлж ажиллах | Ажилчид | - | - | Өдөр бүр | Үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх орон тооны бус комисс”-ыг байгуулсан асаралтаас сэргийлэх дотоод журам |
| 2. | | Ажилчдыг үргэлжлүүлэн ХАБЭА сургалтад хамруулах | | 2 | 300,000 | 600,000 | Улиралд 1 удаа |
| 3. | | Уурхайн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор уурхайд ажиллах аюулгүйн санамжийн самбарын бүрэн бүтэн байдлыг шалгах | Уурхайн кемп | 4 | - | Улиралд 1 удаа | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль<br><br>MNS 5566:2005 Галын аюулаас хамгаалах. Аж ахуйн нэгж, байгууллага барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм. |
| 4. | Гал түймэр | Уурхайн галын хорыг цэнэглэж, ажиллагааг хангах | Галын булан | - | 50,000 | 50,000 | Жилд 1 |
| 5 | Ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх | Ажилчдыг эрүүл мэндийн шинжилгээ оношилгоонд хамруулж, ажлын байранд эмийн санг бэлтгэх | Ажилчид | 1 | - | 2,000,000 | Жилд нэг удаа |
| | **Нийт зардал** | | | | | **2,650,000 ₮** | |

## 4.9 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хүрээнд ахуйн болон аюултай хог хаягдал үүсэхээс сэргийлж өмнөх онуудад дараах ажлуудыг хийж гүйцэтгэн, тогтмол хэрэгжүүлж байна. Үүнд:

- Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ахуйн, дахин ашиглагдах, аюултай хаягдал гэж ангилан ялгаж Дархан хотын Тохижилт үйлчилгээний газартай байгуулсан гэрээний дагуу сар бүр тээвэрлүүлж, хураамжийг төлдөг.
- Хог хаягдлын цэгийн ойр орчимд сард 2 удаа цэвэрлэгээ, ариутгалыг хийдэг.
- Ажилчдад ил задгай хог хаяхгүй байх, ил задгай бие засахгүй байх санамж, зааварчилгааг тогтмол өгдөг.
- Хүнд даацын машин механизмын үйл ажиллагаа, хөдөлгөөнөөс ШТМ гарч, орчин тойрны дам бохирдлыг үүсгэж болзошгүй тул анхаарал болгоомжтой ажиллах, засвар үйлчилгээг зориулалтын талбайд гүйцэтгэх.

2026 оны Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг Хүснэгт 4-5-д тусгав.

*Хүснэгт 4-5 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө*

| № | Хог хаягдлын ангилал | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Хамрах хүрээ | Тоо хэмжээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал, ₮ | Нийт зардал, ₮ | Хэрэгжүүлэх хугацаа | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 1. | Ахуйн | Ахуйн хог хаягдлыг гэрээт байгууллагад тээвэрлүүлэх, актаар хүлээлгэж өгөх | Уурхай | 12 | удаа | 20,000 | 240,000 | Сард 1 удаа | -Хог хаягдлын тухай хууль |
| 2. | | Хог хаягдлын бүртгэл хөтлөх | Уурхай | Зардал гарахгүй | | | | Өдөр бүр | |
| 3. | | Хогийн сав болон цэгийг цэвэрлэх | Хогийн цэг | 12 | удаа | 10,000 | 120,000 | Сард 1 удаа | |
| 4. | Аюултай | Тээврийн хэрэгслийн ашиглалтаас гарсан дугуй, тоормосны шингэн, түлшний тос, түлш хийсэн хуванцар сав, зэрэг аюултай хог хаягдалд хамаарах үүссэн аюултай хог хаягдалд бар код нааж, эрх бүхий байгууллагад нийлүүлж, устгуулах | Тээврийн хэрэгслийн хаягдал | - | - | Гэрээт байгууллагын үнийн саналын дагуу хүлээлгэж өгөх | | Улиралд 1 удаа | -Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, Тээвэрлэх, дахин боловсруулах, устгах Болон бүртгэх, тайлагнах журам |
| Нийт зардал | | | | | | | 360,000 ₮ | | |

## 4.10 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь үйл ажиллагааны нөлөөлөлд өртөх болон өртөж болзошгүй байгаль орчны бүрдэл хэсгүүд, тэдгээрийн төлөв байдлыг тодорхойлох үзүүлэлтүүд, төсөл хэрэгжих орчинд амьдардаг, нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн амьжиргаа, нийгмийн болон эрүүл мэндийн байдлыг илтгэх гол үзүүлэлтүүд, тэдгээрт хэмжилт, дээжлэлт хийх шинжилгээний аргууд, хяналтын цэгийн байршил, хяналт хийх хугацаа ба давтамж зэргийг бүхэлд нь тусгасан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННҮ)-ний чухал хэсэг юм.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын 1.5-т зааснаар Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт нөлөөлөлд өртөж бүй байгаль орчны дор дурдсан бүрдэл хэсгүүдийг заавал тусгаж, бүрдэл хэсэг тус бүрээр хяналт шинжилгээ хийх цэгийн байршил, хэмжилт, дээжлэлт авах үзүүлэлт, тоо, хугацаа, давтамж, зарцуулах зардал, хариуцан гүйцэтгэх этгээд, баримтлах стандарт, аргачлалыг нарийвчлан тусгана.

Сонголон Хайрхан ХХК нь 2025 оны БОМТ-ний орчны хяналт шинжилгээний хүрээнд  дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Агаарт орчны тоосжилт, агаар бохирдуулагч хийг тодорхойлуулсан
- 3 цэгээс дээж авч хөрсний ерөнхий хими болон хүнд металлыг тодорхойлуулсан
- Уурхайн шүүрлийн усанд агуулагдах химийн хэрэгцээт хүчилтөрөгч, биологийн хэрэгцээт хүчилтөрөгчийг шинжлүүлсэн
- Ургамлын мониторингийг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлсэн.

Их Булангийн элс хайрганы ордын 2026 оны үйл ажиллагааны явцад Хүснэгт 4-6-д тусгасан орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг доорх хөтөлбөрөөр хэрэгжүүлнэ. Үүнд:

- Дотоод хяналт шинжилгээний хөтөлбөр буюу Сонголон Хайрхан ХХК нь уурхайн үйл ажиллагаанаас бий болж бүй үр дагаврууды хянах, илрүүлэх зорилгоор уурхайн талбайд агаар, хөрс, усны шинжилгээг жилд 2 удаа хийх
- Уурхайн талбайд жилд нэг удаа ургамал ургалтын үед, ургамлын судалгааг хийх
- Гадаад буюу хөндлөнгийн хяналт шинжилгээний хөтөлбөр буюу хөндлөнгийн хяналт шинжилгээний байгууллагаар орчны хяналт шинжилгээг жилд 1 удаа хийлгэх, дотоод хяналт шинжилгээтэй харьцуулах, дүгнэх

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг Сонголон Хайрхан ХХК бүрэн хариуцна.

*Хүснэгт 4-6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр*

| № | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд | Хяналтын цэгийн байршил | Цэгийн тоо | Давтамж | Нэгжийн зардал, ₮ | Нийт зардал, ₮ | Баримтлах эрхзүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|
| *1* | | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| ***Агаарын чанар*** | | | | | | | |
| 1. | • Орчны тоосжилт ($PM_{2.5}$, $PM_{10}$ TSP)<br>• Агаарын температур, чийг | Уурхайн карьер, тээврийн зам | 2 | Жилд 2 удаа | 300,000 | 600,000 | ***MNS.4585:2016.*** Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага |
| ***Агаарын чанар (хөндлөнгийн хяналт)*** | | | | | | | |
| 2. | • Орчны тоосжилт ($PM_{2.5}$, $PM_{10}$ TSP)<br>• Агаар бохирдуулагч хий ($SO_2$, $NO_2$)<br>• Дуу чимээ | Уурхайн карьер, дотоод тээврийн зам, хяналтын цэг | 3 | Жилд 1 удаа | 1,200,000 | | ***MNS.3384:1982.*** Байгаль орчны хамгаалал. Агаар мандал. Сорьц авахад тавих ерөнхий шаардлага |
| ***Хөрсөн бүрхэвч*** | | | | | | | |
| 3. | • Хөрсний хими болон физикийн ерөнхий шинижлгээ | Хөрсний овоолго, уурхайн карьер, хяналтын цэг | 3 | Жилд 2 удаа | 30,000 | 180,000 | ***MNS.2305:1995.*** Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх |
| ***Хөрсөн бүрхэвч (хөндлөнгийн хяналт)*** | | | | | | | |
| 4. | • Хөрсний хими болон физик<br>• Хүнд металл | Хөрсний овоолго, уурхайн карьер, хяналтын цэг | | Жилд 1 удаа | 900,000 | | ***MNS.5850:2019.*** *Хөрсний чанар.* Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ |
| ***Усан орчин (хөндлөнгийн хяналт)*** | | | | | | | |
| 5. | • Цэвэрлэсэн бохир усны биохимийн шаардлагатай хүчилтөрөгч болон химийн шаардлагатй хүчилтөрөгч | Уурхайн шүүрлийн ус | | Жилд 1 удаа | 800,000 | | ***MNS.6230:2010.*** Бохир ус зайлуулах цэг тогтоох. Ерөнхий шаардлага |
| ***Ургамлан нөмрөг (хөндлөнгийн хяналт)*** | | | | | | | |
| 6. | • Ургамлын зүйлийн бүрдэл<br>• Ургамлан нөмрөгийн бүрхэц | Уурхайн талбай | - | Жилд 1 удаа | 1,320,000 | | Батлагдсан арга зүйн дагуу |
| ***Нийт зардал*** | | | | | ***5,000,000 ₮*** | | |

## 4.11 УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөөний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Ажилчдад ХАБЭА, үйлдвэрийн осол, химийн бодистой харьцах зэрэг сэдвийн хүрээнд сургалтыг зохион байгуулдаг.
- Сонголон Хайрхан ХХК нь Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлгийн Поликлиник-тэй хамтран үйлдвэрийн ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулдаг бөгөөд хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангадаг.
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль” –ийн $10^1$ дугаар зүйлд заасны дагуу Байгаль орчны аудитын мэргэжлийн байгууллага болох Энвайроментал Комплайнц ХХК-р хийлгүүлсэн.
- 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулсан бөгөөд биелэлтийн тайланг 11-р сарын 01-ны өдрөөс өмнө цахим мэдээллийн санд оруулсан.

2025 оны удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөг Хүснэгт 4-7-д тусгав.

*Хүснэгт 4-7. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө*

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Урьдчилан тооцсон төсөв сая ₮ | Хэрэгжүүлэх хугацаа 2026 он | | | Хариуцсан албан тушаалтан |
|---|---|---|---|---|---|---|
| | | | IV | VIII | XII | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| *1.* | Жилд 1 удаа мэргэжлийн байгууллагатай хамтран ажилчдад ХАБЭА сургалт зохион байгуулах | 1,000,000 | | + | | ХАБЭА ажилтан |
| *2.* | Ажилчдыг үргэлжлүүлж эрүүл мэндийн үзлэгт хамруулах | ҮАЗ* | + | | | Удирдлага |
| *3.* | Газрын гэрээг дүгнүүлж, акт авах | ҮАЗ* | | | + | Хариуцсан мэргэжилтэн |
| *4.* | Жил бүр БОМТ-г батлуулж, биелэлтийн тайланг Дархан-Уул аймгийн БОАЖГ-т хүргүүлэх | - | | | + | Хариуцсан мэргэжилтэн |
| **Нийт зардал** | | **1,000,000 ₮** | | | | |

***Тайлбар:*** *ҮАЗ* - Үйл ажиллагааны зардалд тусгах*

Сонголон Хайрхан ХХК нь 2021.06.30 өдөр Энвайроментал Комплайнц ХХК-иар аудитыг хийлгэсэн. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн $10^1$ дэх заалт болон Ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасны дагуу 2 жил тутамд байгаль орчны аудитыг хийлгэх шаардлагатай учир 2025.09.30 өдөр Энвайроментал Комплайнц ХХК-иар аудитыг дахин хийлгэсэн. Дараагийн байгаль орчны аудитыг 2027 онд хийлгэхээр төлөвлөж байна.

## 4.12 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж, батлагдсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тодорхойлсон сөрөг нөлөөг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг үндэслэн жил бүрийн 12 дугаар сард багтаан дараа оны тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулна. БОМТ-г боловсруулж, Дархан-Уул аймгийн БОГ-т батлуулахаар хүргүүлж, батлагдсаны дараа тухайн жилийн БОМТ-г ханган биелүүлж, түүний үр дүнг тусгасан биелэлтийн тайланг тухайн оны 11 дүгээр сарын 01-ний дотор харьяалагдах аймгийн байгаль орчны газарт хүргүүлнэ.

Орон нутгийн байгаль орчны газраас тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянасны дараа хяналтын хуудсыг гаргаж өгөх бөгөөд төсөл хэрэгжүүлэгч нь энэхүү хуудсыг тухайн оны БОМТ-ний биелэлтийн тайланд хавсарган өгнө.

*Хүснэгт 4-8. БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах хуваарь*

| № | БОМТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд | Тайлагнах хэлбэр | Мэдээллийн агуулга | Зохион байгуулах хугацааны тов | Тайлагнах зардал, сая төг | Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан | Зохион байгуулах газар |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Дархан-Уул аймгийн байгаль орчны газар | Хэвлэмэл | Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн түүний үр дүнг тусгасан тайлан байна. Ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой фото зургаар баталгаажсан байна. | 11 дүгээр сарын 01-нээс өмнө | ҮАЗ* | Удирдлага болон Байгаль орчны мэргэжилтэн | Дархан-Уул аймаг |
| 2. | БОУАӨЯ | Хэвлэмэл болон (www.eic.mn ) | Тухайн жил хийх ажлын төлөвлөгөө | 12 дугаар сарын 30-наас өмнө | | | Улаанбаатар хот |

Сонголон Хайрхан ХХК нь жил бүр БОМТ боловсруулан БОУАӨЯ-аар батлуулж, БОМТ-нд тусгагдсан ажлуудыг ханган биелүүлж, БОМТ-ний биелэлтийн тайланг жил бүр Дархан-Уул аймгийн БОГ-т хүргүүлэх үүрэгтэй.

# ДҮГНЭЛТ

Сонголон Хайрхан ХХК-ийн Их Булангийн элс хайрганы ордын 2026 оны БОМТ-г боловсруулан дараах дүгнэлтийг хийж байна.

Их Булангийн элс хайрганы ордын 2026 оны БОМТ-ний хүрээнд сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд 2.8 сая, ногоон байгууламжийн төлөвлөгөөнд 13.03 сая, биологийн олон янз байдлыг хамгаалах төлөвлөгөөнд 21 сая, осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд 2.65 сая, хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд 0.36 сая, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт 5.0 сая, удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 1.0 сая төгрөг тус тус төлөвлөв.

Сонголон Хайрхан ХХК нь 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд ₮45,840,000 зарцуулан 30 ажил хийж гүйцэтгэхээр байна.

Сонголон Хайрхан ХХК нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхийн баталгаа болгон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлынхаа 50-иас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг Дархан сумын Засаг даргын дэргэдэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлнэ.

# ХАВСРАЛТ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ


| № | Хавсралтын нэр | Хуудас |
|---|---|---|
| 1. | Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар | 2 |
| 2. | Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн хуулбар | 4 |
| 3. | Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөөний баталгаажсан нүүр | 1 |
| 4. | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хяналтын хуудас | 5 |




Хууль зүйн сайдын 2016 оны
А/204 дүгээр тушаалаар батлав.

МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ
000188827

2008.12.17 / Бүртгэсэн он,сар,өдөр /
9011179051 / Хувийн хэргийн дугаар /
5276764 / Регистрийн дугаар /

Сонголонхайрхан Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр 01 2008.12.17
/ шийдвэрийн нэр / / дугаар / / он, сар, өдөр /


0111 Газар тариалан эрхлэх
0141 Фермерийн аж ахуй эрхлэх
4610 Гадаад худалдаа
0210 Газрын хэвлийн нөхөн сэргээлт
7490 Хатуу хучилттай зам барих
/ код / / Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /
/ код / / Түүнээс эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

12.01.12~15.01.12 / хугацаа / 2 / гишүүдийн тоо / 2,452,970.0 / өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Сонгинохайрхан, 12-р хороо, 182, Утас1: 98009669, Утас2: , Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

Улсын бүртгэлийн ерөнхий газар
Хуулийн этгээдийн улсын
бүртгэлийн газар
/ бүртгэсэн байгууллагын нэр /

Гэрчилгээ дахин олгосон 2019 он 8 сар 28 өдөр



БАТЛАВ.
ДАРХАН ХОТЫН ХОГ ТЭЭВЭР
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА
Л.ОТГОНБАЯР

БАТЛАВ.
.....
.....и ЗАХИРАЛ/ДАРГА/
.....
Дархан-Уул аймаг

No 33

ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ ТҮРЖ, БУЛЖ УСТГАХ ГЭРЭЭ

Гүйцэтгэгч талаас "ДАРХАН ХОТЫН ХОГ ТЭЭВЭР ОНӨААТҮГ"- г төлөөлж ахлах байцаагч.....Г. Фаярмаа..... нөгөө талаас.....газрын.....ерөнхий менежер.....албан тушаалтай Г.Гонгорын.....цаашид захиалагч тал гэх/ нар нь "Монгол Улсын Хог Хаягдлын тухай хууль", Зөрчлийн тухай хууль" эдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудыг үндэслэн харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Энэхүү гэрээний зорилго нь гүйцэтгэгч тал нь ААНБ-аас гарч байгаа ахуйн болон энгийн хог хаягдлыг гэрээнд заасны дагуу ачиж тээвэрлэх, түрж булж устгах, захиалагч тал нь гэрээнд заасан хугацаанд төлбөр төлөх, хог хаягдлыг ачиж тээвэрлэж Бараат хогийн цэгийн талбайд буулгах харилцаа болон байгууллага хоорондын ажлын уялдааг сайжруулж хариуцлагыг дээшлүүлэхэд оршино.

Нэг. Нийтлэг заалт

1.1 Захиалагч нь өөрийн байгууллагын ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг өөрийн тээврийн хэрэгслээр ачиж тээвэрлэн Дархан-Уул аймгийн Дархан сум 6-р баг Бараат хогийн цэгийн талбайн тогтоосон цэгт буулгах, гүйцэтгэгч тал уг хог хаягдлыг түрж булж устгах ажлыг хариуцан гүйцэтгэнэ.

1.2 Гүйцэтгэгч тал хог хаягдлыг холбогдох хууль, тогтоомж, дээд газрыж шийдвэр, журамд заасан хэм хэмжээний дагуу булж устгах ажлыг гүйцэтгэнэ.

Хоёр. Гэрээний хугацаа

2.1 Энэхүү гэрээ нь 2025.оны 01.сарын ны өдрөөс 2025 оны 12 сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

2.2 Гэрээний хугацаа дуусахад талууд харилцан тохиролцож сунгаж болно.

Гурав. Гэрээний үнэ, төлбөр тооцоо

3.1 Гэрээний дагуу 1м3 хог хаягдлыг булж устгах, үйлчилгээний тарифыг -10,000 /арван мянга/-н төгрөгөөр тооцно. Төлбөрийг тухайн сарын 25-30-ны дотор тооцоо



ОРЛОГЫН МЭДУУЛЭГ

Дархан хотын хог тээвэр ОНӨААТҮГ

Баримтын 30400

Хураамж төлсөн:
20 ... он ... сар

Хэнээс .....
Хороолол ..... байр ..... тоот

Бүтэн дүн
10,000

Бичгээр
Арван мянгаа

он | сар | өдөр
2025 | 1 | 15

Байцаагч: .....
Гүйцаагч: .....